

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол улсад шударга ёс, хариуцлага, хөгжил цэцэглэлийг төлөвшүүлэхийн төлөөх хамтрагч

## ХҮН ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ ГЭР БҮЛД АМЬДРАХ ЭРХТЭЙ: ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ НИЙГМИЙГ СУРГАХ НЬ

Энхжаргал 10 жилийн тэртээ Хуулийн сургуулийн төгсөх ангид суралцаж байх үеэсээ Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв /ХЭҮТ/-д өөрийн сайн дураар ажиллаж эхэлсэн. Хүүхдийн хүнд хэцүү амьдрал, өөрийн ээжийн нөлөөгөөр тэр хүний эрхийн төлөө идэвхтэй тэмцэгч болсон тэрбээр ХЭҮТ-хэмээх хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн хүний эрхийн байгууллагыг хөдөлгөгч гол хүч нь юм.

Намайг нэлээд жаахан байхад нэгэн эмэгтэй өөрийг нь алахаар заналхийлдэг нөхрөөсөө эмээж манай гэрт 10 хоног нуугдсан гэж Энхжаргал тайлбарлаад олон жилийн өмнө тохиолдсон хэр нь тэр хэрэг явдал хуулийн мэргэжил сонгох, хүмүүсийг ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалдаг болох шийдвэрт маань нөлөөлсөн. Нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл газар авсан оронд Энхжаргал болон ХЭҮТ-д эрх зүйн болон нийгмийн олон сорилт тулгардаг боловч нааштай ахиц гарсаар байна.

2003 онд ХЭҮТ Азийн сангийн дэмжлэгтэйгээр лобби хийх, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх томхон кампани өрнүүлсэнийн үр дүнд Гэр бүлийн хүчирхийллийн тухай анхны хууль Монгол улсад батлагдсан юм. Энэхүү хууль гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран шийдвэрлэх, хорогдох байруудыг бий болгож, улмаар бэхжүүлэх, хохирогсдын хамгаалалт, тэдэнд зөвлөгөө өгөх явдлыг боловсронгуй болгох, гэм буруутнуудыг цагдан саатуулах шийдвэр гаргуулах, уг шийдвэрийг мөрдүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь хохирогсдод дэмжлэг үзүүлэх, эрх зүйн хувьд нь төлөөлөх зэрэг нөхцлийг бүрдүүлсэн. 2003 оноос хойш ХЭҮТ дөрвөн хорогдох байрыг нээж, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааг энэ талын мэдээлэл, үйлчилгээ хомс хөдөө орон нутагт өргөжүүлсэн. Улаанбаатар хот дахь хорогдох байр дангаараа жил тутам гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нэг мянга гаруй хохирогчдод эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.



Энхжаргал ХЭҮТ-ийн ажилнуудын багийг бүрдүүлж бэхжүүлсэн

ХЭҮТ нь эмэгтэйчүүд, хүүхдүүдэд аюулгүй, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэхийн тулд Азийн сан болон MYTWO– сангийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хот дахь хорогдох байраа шинэчлэн өргөжүүлсэн бөгөөд үндэсний хэмжээнд хууль сахиулах байгууллагын ажилтнуудад төрөлжсөн сургалт явуулах сургагчдын багийг бэлтгэн, хэрэглэгдэх гарын авлага материалуудыг боловсруулж бэлэн болгосон байна. ХЭҮТ-ийн сургалт цагдаагийн ажилтнуудыг хэрэг илрүүлэх, түүнтэй тэмцэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд сургаж, ажил эргэйн эерэг харилцаа тогтоосон байна. Анхны дуудлагыг хүлээн авдаг цагдаагийн байгууллагын ажилтан хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэхэд илүү дадлагатай болсон. Энхжаргалын хэлсэнээр гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн, тэр ч байтугай үндэсний аюулгүй байдлын асуудал гэхээс илүүтэйгээр хэн нэг хүний хувийн асуудал мэт ойлгодог байсан төрийн болон цагдаагийн байгууллагын хандлагыг Азийн сан, MYTWO болон бусад сан өөрчилж байна.



ХЭҮТ-өөс цагдаагийн ажилтнуудад зориулан зохиосон сургалт

### МОНГОЛ УЛС

Нийт  
эмэгтэйчүүдийн  
гуравны нэг нь  
гэр бүлийн  
хүчирхийлэлд  
өртдөг, таван өрх  
тутмын нэгд  
хүчирхийлэл  
үйлдэгддэг.  
ХЭҮТ-ийн  
судалгаа /1995  
он, 1998 он, 2000  
он/

Хамрагдан  
оролцоно уу!  
Азийн санд  
харьяалдаг, АНУ-  
ын ашгийн төлөө  
бус Give2Asia  
хандив өгөх  
ажиллагааг  
хялбаршуулж,  
албан татвараас  
суутгуулах  
боломж олгодог  
олон нийтийн  
буяны үйл  
ажиллагааны  
тухай хуулийн  
501/с/ /3/дагуу  
тэмдэглүүлнэ үү.  
[www.give2asia.org](http://www.give2asia.org)  
g